



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/15

Чингис хот

Соёлын төвүүдийг шагнаж, урамшуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны 07 сарын 17-ны А/391 тоот захирамжийн дагуу зохион байгуулсан "Соёлын төв - Чанартай үйлчилгээ – IV" уралдаанд оролцож, эхний 3 байр эзэлсэн соёлын төвүүдийг шагнаж, урамшуулахад 705000 /долоон зуун таван мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсрагтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг шагнал урамшил буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010065

Аймгийн Засаг даргын 2021 оны
..01... дугаар сарын 13... өдрийн 1/15.....
дугаар захирамжийн хавсралт



“Соёлын төв чанартай үйлчилгээ- IY ”
улсын уралдааны шагналын төсөв

д/д	Шагнал авах соёлын төвүүдийн нэр	Шагналын нэр		Нийт дүн
		Өргөмжлөл мөнгөн дүнгээр	Мөнгөн шагнал	
1	Батноров сумын соёлын төв	35.000	250.000	285.000
2	Дадал сумын соёлын төв	35.000	200.000	235.000
3	Бэрх тосгоны соёлын төв	35.000	150.000	185.000
Нийт				705.000